



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Шагнаж урамшуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Яамны удирдлагын зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тэргүүн байрт шалгарсан Эрүүл мэндийн газар, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг хавсралтын дагуу баталсугай.

2. Тэргүүн байрт шалгарсан Эрүүл мэндийн газар, харьяа эрүүл мэндийн байгууллагыг 3 сая төгрөгөөр, хоёрдугаар байрт шалгарсан байгууллагыг 2 сая төгрөгөөр, 3 дугаар байрт шалгарсан байгууллагыг 1 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсугай.

3. Шагнал урамшуулалд шаардагдах 12000000 (арван хоёр сая) төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д зөвшөөрсүгэй.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080246

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 3 сарын 02 өдрийн
БХ дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2015 ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГУУД

1. Эрүүл мэндийн байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тэргүүн байрт шалгарсан Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
 - Тэргүүн байрт: Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
 - Дэд байрт: Улсын гуравдугаар төв эмнэлэг
 - Гутгаар байрт: Арьсны өвчин судлалын үндэсний төв
2. Эрүүл мэндийн байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тэргүүн байрт шалгарсан Эрүүл мэндийн газрууд
 - Тэргүүн байрт: Нийслэлийн эрүүл мэндийн газар
 - Дэд байрт: Архангай аймгийн Эрүүл мэндийн газар
 - Гутгаар байрт: Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар